



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/847

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус “Ковид-19”-ын цар тахлыг бууруулах эмчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд хүргэх эмнэлэгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор Жаргалант сумын 5 Эрүүл мэндийн төв, Зооноз өвчин судлалын төвд гэрэгэ пос төхөөрөмж худалдан авахад 9 000 000 төгрөг, пос машины цаас худалдан авахад 1 980 000 төгрөг, аймгийн Нэг цэгийн үйчилгээний төв Биеийн тамир, спортын газрын фестүүл, том заалны агаар сэлгэлтийг нэмэгдүүлэхээр сорох вентилятор, агаар сэлгэлтийн хоолой холбох ажлын зардалд 1 000 000 төгрөгийг тус тус хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 11 980 000 төгрөг /Арван нэгэн сая есөн зуун наян мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас хамгаалах зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 23-ны өдрийн
А/847 дугаар захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	Гэрэгэ пос төхөөрөмж	ш	6	1 500 000	9 000.0
2.	Пос машины цаас	Боод	600	3 300	1 980.0
3	Цэг цэгийн үйлчилгээний цэг /БТСГ/-ийн агаар сэлгэлт, материал ажлын хөлс	ш	1	1 000 000	1 000.0
	ДҮН				11 980.0

-oOo-